



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 06

Улаанбаатар хот


Төсөв тодотгох тухай

Дээд боловсролын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.5 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2025 оны үйл ажиллагааны төсвийн орлогыг нэгдүгээр хавсралтаар, төсвийн зарлагыг хоёрдугаар хавсралтаар, хөрөнгө оруулалт, урсгал засвар, бараа, ажил үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар тус тус тодотгол хийж, өөрчлөн баталсугай.

2.Тус их сургуулийн төсвийг батлагдсан төсвийн хүрээнд холбогдох хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнаж ажиллахыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Ректор (Т.Намнан)-т даалгасугай.

3.Энэхүү тогтоол гарсантай холбогдуулан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Төсөв батлах тухай" 16 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Д.ТАНТУЛГА

367010011



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

Хичээлийн 5-р байрны дадлагын зориулалттай хэсгийг буулгаж, дахин төлөвлөлт хийх тухай


Боловсролын ерөнхий хуулийн 39.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх” журмын 1.2, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.5 дахь заалт, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хичээлийн 5-р байрны ашиглалтын шаардлага хангахгүй байгаа дадлагын зориулалттай хэсэг (нийт 2574 мкв бүхий, 66х39 м хэмжээтэй, 5,18м өндөртэй метал каркастай дан барилга)-ийг буулгаж, дахин төлөвлөлт хийхийг дэмжсүгэй.

2.Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн хичээлийн 5-р байрны ашиглалтын шаардлага хангахгүй байгаа дадлагын зориулалттай хэсгийг ашиглалтаас хасах, буулгах, үндсэн хөрөнгийн данснаас хасах саналыг Боловсролын яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тус тус уламжилсугай.

3.Хичээлийн 5-р байрны ашиглалтын шаардлага хангахгүй байгаа дадлагын зориулалттай хэсгийг буулгах болон дахин төлөвлөлтийн судалгаа, зураг төсөл боловсруулах зардлыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2026 оны төсвийн төсөлд тусган хэлэлцүүлэхийг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-т даалгасугай.

4.Хичээлийн 5-р байрны дадлагын зориулалттай хэсгийн дахин төлөвлөлтийн хүрээнд барилга, байгууламж барих, тохижилт хийхэд шаардлагатай санхүүжилтийг олон талт эх үүсвэрээс босгохыг Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-т зөвшөөрсүгэй.



367010013



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 08


Улаанбаатар хот

“Гарааны Эм Эн Жи инно куайлити фюэл” компани байгуулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Инновацийн тухай хуулийн 3.1.8, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн дүрмийн 3.8.2 дахь заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.2, 4.5 дахь заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн дэргэд ашигласан тосноос дизелийн түлш үйлдвэрлэх “Гарааны Эм Эн Жи инно куайлити фюэл” хязгаалагдмал хариуцлагатай компанийг байгуулсугай.

2. “Гарааны Эм Эн Жи инно куайлити фюэл” хязгаалагдмал хариуцлагатай компанийн дүрмийн санд Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эзэмших хувийг тогтоон, компанийн дүрмийн төслийн хамт Удирдах зөвлөлд эргэн танилцуулах, хамтрагч, хөрөнгө оруулагч, оролцогч талуудтай гэрээ хэлэлцээр байгуулах, компанийг улсын бүртгэлд бүртгүүлж, үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-д даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТУЛГА

367010017



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 11 сарын 12 өдөр

Дугаар 09

Улаанбаатар хот

“Гарааны Смарт майнд Эй Ай Лаб” компани байгуулах тухай

Дээд боловсролын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4, Инновацийн тухай хуулийн 3.1.8, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн дүрмийн 3.8.2 дахь заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн дүрмийн 4.1.2, 4.5 дахь заалт, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Удирдах зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан технологийн их сургуулийн дэргэд хиймэл оюун ухаан, блокчейн технологи ашиглан бүтээгдэхүүн, үйлчилгээ хөгжүүлэх “Гарааны Смарт майнд Эй Ай Лаб” хязгаалагдмал хариуцлагатай компанийг байгуулсугай.

2. “Гарааны Смарт майнд Эй Ай Лаб” хязгаалагдмал хариуцлагатай компанийн дүрмийн санд Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эзэмших хувийг тогтоон, компанийн дүрмийн төслийн хамт Удирдах зөвлөлд эргэн танилцуулах, хамтрагч, хөрөнгө оруулагч, оролцогч талуудтай гэрээ хэлэлцээр байгуулах, компанийг улсын бүртгэлд бүртгүүлж, үйл ажиллагааг эхлүүлэхтэй холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Шинжлэх ухаан технологийн их сургуулийн ректор (Т.Намнан)-т даалгасугай.

ДАРГА  Д.ГАНТУЛГА

367010015